



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар A/220

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 4.1.108, аймгийн Засаг даргын 2017 оны а/525 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт-хөгжил” хөтөлбөрийн 4.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монголын нутгийн удирдлагын холбоотой хамтран Улаанбаатар хотод зохион байгуулж буй “Багийн Засаг дарга нарын манлайлал, ур чадвар” сэдэвт сургалтад 61 багийн Засаг даргыг оролцуулж, тус 2 өдрийн сургалтын зардалд 3.050.000 (гурван сая тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 3.050.000 (гурван сая тавин мянга) төгрөгийг аймгийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100491